

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-5

1. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	3-4
2. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	4-5

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Ж.Батжаргал ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Х.Болорчулуун, Н.Ганибал, Г.Мөнхцэцэг, Д.Өнөрболор, Ц.Туваан, О.Цогтгэрэл.

Нэг. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Хуралдаан 11 цаг 32 минутаас 12 цаг 11 минутад түр завсарлав.

Хоёр. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын дарга Д.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалын гаргасан, “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 08 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 13 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ж.БАТЖАРГАЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 26 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Батжаргал: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны 2024 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанд 52,6 хувийн ирцтэй байна. Батжаргал, Бат-Эрдэнэ, Ганболд, Дамдинням, Идэрбат, Наранбаатар, Тэмүүлэн, Бейсен, Энхтүвшин нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Нэг асуудал хэлэлцэнэ. Түрүүний хуралдаанаас түр хойшлуулчихсан асуудал байгаад байгаа. Өнөөдрийн хуралдаан ирц бүрдсэн тул эхэлж байна.

Нэг. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн. Энэ асуудлыг хэлэлцэхээр тогтоож байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудлаа тогтлоо, баталлаа. Хууль санаачлагчийн танилцуулгыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг хийнэ.

С.Чинзориг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Байгаль орчны тэнцвэрт байдал, байгалийн унаган төрх, түүх, соёлын үнэт өвийг хадгалах, биологийн төрөл

зүйлийг хамгаалах, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд онцгой ач холбогдол бүхий Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгон улсын тусгай хамгаалалтад авахаар холбогдох судалгаа хийж, үндэслэлийг боловсруулан танилцуулж байна.

Энэхүү тогтоолын төсөлд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын байгалийн дурсгалт газрыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газар болгохоор улсын тусгай хамгаалалтад авах суурь судалгаа, үндэслэлийг шинжлэх ухааны байгууллагатай хамтран боловсруулж, орон нутгийн ИТХ-аар хэлэлцүүлэн холбогдох тогтоол шийдвэрийг гаргуулсан болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу 2024 оны 3 дугаар сарын 11-ний өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яамны цахим хуудсанд тогтоолын төслийг нээлттэй байршуулсан болно. Булган уулыг дархан цаазат газар болгосноор байгалийн өвөрмөц тогтоц, унаган төрх, түүх соёлын дурсгалууд, ховор амьтан, ургамал, гол мөрний урсац бүрэлдэн бүрэлдэх эх, ойн сан бүхий газар хамгаалагдах юм. Дархан цаазат газар болгосноор хамгааллын менежментийг Монгол Улсын ЗГ-ын 2006 оны 87 дугаар тогтоолын дагуу дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт 1 байгаль хамгаалагчийн хариуцах талбайн хэмжээтэй уялдуулан орон тоог тогтоох, цалингийн санд өөрчлөлт оруулах замаар Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа хариуцан хэрэгжүүлэх боломжтой болно.

Тогтоол батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын 2000, 1995 оны Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг шинэчлэх тухай 26 дугаар тогтоол, тогтоолын

холбогдох заалтуудад өөрчлөлт орох болно.

Эрхэм Байнгын хорооны гишүүд та бүхнийг Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолыг хэлэлцэн, дэмжснэ өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Ж.Чинзориг: Чинзориг сайдад баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дулаанжаргалын Ганзориг мөн яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын дарга.

Хууль санаачлагчийн танилцуулгатай холбогдуулж асуух асуулттай гишүүд байна уу? Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна. Тэгвэл Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжснэ гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Саранчимэг хаачих гэж байгаа юм бэ? Би санаад байх юм. Тэгээд 5 л болчихоод байна л даа, 1 нэмэгдчихвэл. Энхтүвшин хаана яваа юм бэ? Энхтүвшин ч байгаа шүү дээ хажууд ойрхон.

Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалынх нь хүрээнд хэлэлцэхийг дэмжснэ гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд суудлаа эзлээрэй. Гишүүд суудлаа эзлээрэй. Болно, болно. Санал хураалт. 63,6 хувиар хэлэлцэхийг дэмжлээ. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн танилцуулна.

11.32 цаг

Байнгын хорооны хуралдааныг түр завсарлуулъя.

Хуралдаан 11 цаг 32 минутаас 12 цаг 11 минутад түр завсарлав.

Байнгын хорооны гишүүдийнхээ өдрийн амгаланг дахин айлтгая. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд туссан байна. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж асуулт, саналтай гишүүн бий юү? Алга байна. Хэлэлцэх асуудлаа баталлаа.

Хоёр. “Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2024.06.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэх асуудалдаа оръё. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүн түрүүнийх хэвээрээ. Төрийн нарийн бичиг, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын дарга нар оролцож байгаа гэдгийг хэлье.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж асуулттай гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүн байна уу? Алга байна. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангиллыг өөрчлөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй тул төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг гаргаж байна. Энэ саналын томъёоллоор санал хураалтыг явуулъя. Манай гишүүд суудлаа эзлээрэй.

Анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргаж байна. Санал хураалт. 60 хувийн саналаар дэмжигдлээ. Анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулна.

12.13 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөж байна. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийн гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

